

Ч.ДАЛАЙ “МОНГОЛ УЛСЫН ХЯТАД СУДЛАЛЫН ТОВЧ БАЙДАЛ”

Академич Ч.Далай гуай 1960 онд дэлхийн хятад судлаачдын XII их хурал дээр “Монголын хятад судлалын байдал” гэсэн илтгэл тавьж, энэ нь хятад хэлээр ном болон хэвлэгдсэн бөгөөд Монголын хятад судлалын түүхэн уламжлал, хөгжлийг анх удаа нэгтгэн дүгнэж дэлхий дахинд танилцуулсан чамбай бүтээл болж, хожмын судлаачдын судалгааны чиг хандлагыг заан тодруулж өгсөн юм. Энэхүү хуралд тавьсан илтгэлийг орчуулан, хэвлэж байгаа нь анх удаагийнх юм.

БНМАУ-ын Шинжлэх Ухаан Дээд Боловсролын Хороо 1960 он

Монгол, Хятад хоёр орон эртний хөрш улс учраас хоёр орны ард түмэн хоёр улсын түүх, ёс заншлын тухайд ч бас эртнээс харилцан ойлголцож иржээ. Бүр МЭӨ VIII-IX зууны хятадын түүхчид түүхэн судартаа Монголын түүхтэй холбогдолтой зүйлсийг тэмдэглэн үлдээжээ. Монголчууд хэдийгээс эхлэн хятад судлалыг сонирхож, хэдий үеэс цаашид ч гүнзгийрүүлэн судалж ирсэнийг тогтоох лавтай түүхэн тэмдэглэл өдгөөг хүртэл хараахан олдоогүй байна.

Зарим нэгэн түүхэн эх сурвалжийг үзвэл, бүр Хүннүгийн үеэс хятад үсгийг ном, албан бичигт хэрэглэж эхэлсэн ба улмаар Хүннүчүүд хятад үсгээр түүхээ тэмдэглэж байжээ. X-XII зуунд Кидан улсын үед тусгай судалгааны газар ба нүүдэлчин, малчин үндэстний түүхийг найруулан бичиж, Ханьлинь Юань буюу судар бичгийн хүрээлэн байгуулж Кидан улс болон Хятадын түүхийг бичих ажлыг хийж байв. Эртний Киданы үеэс монгол хүн кидан бичиг хэрэглэж, энэхүү бичгийг Чингис хааны үеийг хүртэл монголчууд хэрэглэж байв. Монголын олон аймгийн толгойлогч Бодончар (970 онд төрсөн)-ын үед Сүн улстай соёлын харилцаа тогтоожээ. Тухайн үед Хятадын соёл Монголд ихээр нэвтэрч, XIII зууны Монгол ид хүчирхэгжин мандаж байсан үе бөгөөд Монголын феодал язгууртанууд хятад багш, сургагчдыг урих болсоноор Монголд сургууль байгуулж, Монголын феодал язгууртануудын хүүхдүүдэд хятад хэл, бичиг зааж байжээ.

X зуунаас хойш Монголчууд хятад үсэг болон уйгар бичгээр ном, албан бичиг бичиж байсан ба XIII зуунд бичсэн “Монголын нууц товчоо” бол монгол авианд тулгуурлан ханз үсгээр бичсэн монголын алдартай бүтээл бөгөөд тухайн үеийн Монголын хятад судлалын хөгжлийн байдлыг бүрэн гэрчилж байна.

Юань улсын үед сургуульд хятад хэл, соёлыг сурах монгол сурагчдын тоо улам бүр нэмэгдэж байлаа. Тэр үед сурагчдаас шалгалт авахдаа монгол сурагчдад хэдийгээр хятадын оюутнуудын шалгалтын асуултаас амархан байсан ч шалгуулагчид бүхий л хичээлээ сайтар үздэг байв. Иймээс монголын

шалгуулагчид хятадын эртний түүх, утга зохиол, гүн ухааныг зайлшгүй үзэхээс гадна хятад хэл сурах нь улам ихсэж, хятад судлаачид ч өдөр ирэх тусам нэмэгдэж байлаа. Ийм харилцааны улмаас XIII зуунаас эхлэн, монгол хүн хятад судлалыг улам гүнзгий сонирхож, хятад номыг монгол хэл рүү орчуулах ажлыг хийх болсон.

XIII зууны үед Монголын эрдэмтэд бас Монголын түүхийг нарийвчлан судлахын тулд хятадын түүхийн ном сурвалжийг судлаж байлаа.

XIII зууны үед Монголын хааны ордны дэргэд түүх бичих судар бичгийн хүрээлэн байгуулагдаж, Монголын хэсэг эрдэмтэд түүх зохиох их ажилд оролцож байв. XIII зууны үед, монголын эрдэмтэд хятадын түүх, гүн ухаан, утга зохиол болон анагаах ухааны олон тооны ном, бүтээлийг монгол хэлэнд орчуулах ажлыг эхэлсэн юм.

XIII-XX зууны хооронд, Монголын эрдэмтэдийн бүхий л түүхийн судалгааны ажил нь хятад судлалын нэн чухал хэсэг болсон. Үүний зэрэгцээ тэд Хятадын салшгүй нэг хэсэг төвд, манж хэл болон түүхийг судалж эхэлсэн.

Монгол хүн хятад судлалыг судлахын зэрэгцээ хятадын эртний нэртэй бүтээлийг орчуулж, нэмэлт тайлбар хийж, ялангуяа зарим алдартай бүтээлээр эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж байсан.

XIII-XV зууны үед хятад хэлнээс монгол хэл рүү олон бүтээл орчуулсан. Гэвч XV-XVII зуунд шарын шашин монголд нэвтэрсний улмаас төвд хэлээр ном судар бичиж, төвд хэлнээс монгол хэл рүү орчуулах ажил аажмаар дэлгэрсэн. Тухайн үед монголын олон эрдэмтэн төвд хэлээр бүтээлээ туурвидаг байжээ.

Манай улсад одоо хүртэл бүрэн тоог нь гаргаагүй ч үзэхэд, тухайн үеийн 200 гаруй монгол эрдэмтэд төвд хэлээр 490 гаруй ном зохиол бичжээ. Эдгээр бүтээлийн нэлээд хэсэг нь төвдийн түүх, утга зохиол, гүн ухаан болон шашны түүхтэй холбоотой байв.

XVII зуунаас хойш, монгол эрдэмтэд гол төлөв манж бичгээр дамжуулан хятад судлалыг судлахын зэрэгцээ манж хэлнээс хятадын түүх, урлаг болон гүн ухааны гэх мэт зохиол бүтээлийг орчуулж эхэлсэн юм. Тухайн үед төвд хэлээр ном бичих ажил тасралтгүй хийгдэж байв.

XVIII-XX зуунд Монголд хятад судлал болон Хятадын төвд, манжийн судалгаа маш их дэлгэрч байв. Тэр үед Монголын эрдэмтэд манж хэлээр дамжуулан олон тооны хятад ном орчуулж, зарим нэг орчуулагчид, тайлбар буюу оршил, төгсгөлийн үг бичиж хавсаргадаг байв.

Тухайн үеийн хятад судлалын байдлыг тус тусад нь дахин товч дурдвал:

1. Хэлний судалгаа:

XVIII-XX зуунд Монголын эрдэмтэд бие даан эсвэл Хятадын эрдэмтэдтэй хамтран хятад-монгол, төвд-монгол, манж-монгол зэрэг толь бичиг зохиожээ. Түүний дотор тухайлбал 2 тигийн, 3 тигийн, 4 тигийн, 5 тигийн манж бичгийн хөлгөн судар гэх мэт. Монгол хүн бие даан толь бичиг бичсэн нь монгол эрдэмтэн Тэмгээтүгийн “Хятад-Монгол толь” юм.

XIX зууны Монгол эрдэмтэн Ишдоржийн төвд хэлээр зохион бичсэн “Төвд-Монгол авианы толь” юм. Одоо энэхүү толины гар бичмэл нь

хадгалагдсаар байна. Иймэрхүү төрлийн толь бичгийг монгол эрдэмтэд цөөнгүй гаргасан юм. Үүнээс гадна монгол хүн монгол хэлээр хэл шинжлэлийн ном зохиол олон төрлийн толь, ном бүтээл туурвижээ.

2. Түүхийн судлал:

Энэ талын чухал ажил нь хятадын түүхийн ном орчуулах явдал юм. Жишээ нь: эрдэмтэн Дандаачансан олон жил шаргуу хөдөлмөрлөсөний эцэст 1927 онд Юань улсын судрыг бүрэн орчуулж дууссан. Орчуулсан бүх гар бичмэл нь нийт 210 дэвтэр бөгөөд одоог хүртэл манай улсын Улсын номын санд нандигнан хадгалагдаж байна. “Юань улсын судар”-ын орчуулга Монголын түүхийн судалгаанд нэн чухал хувь нэмэр болсон төдийгүй Юань улсын үеийн Хятадын түүхэнд чухал ач холбогдолтой судалгаа болсон юм.

1917 онд Монголын эрдэмтэн Элбэгт, Цэнд “Тан улсын түүх”-ийн 25 бүлгийг монгол хэлэнд орчуулсан. Монголын судар бичгийн хүрээлэнгийн ахмад эрдэмтэн Бат-Очир “Нэвтэрхий товчоо” номын ихэнх хэсгийг монгол хэлэнд орчуулжээ. 1920-1929 онд Бат-Очир “Алтан Улсын түүх” 9 дэвтэр, Ляо улсын түүхээс 8 дэвтрийг, “Турван улсын түүх”-ийг монгол хэлэнд орчуулан хэвлэжээ. Эдгээр орчуулгын ном нь Монголын түүх болон Хятадын түүхийн судалгаанд маш чухал гарын авлага болсон юм.

3. Утга зохиол, урлагын судалгаа :

1900-1914 он хүртэл монголын эрдэмтэн хятадын “Алтан бумбан дахь лишийн цэцэг”, “Тансан лам” буюу “Баруун этгээдэд зорчсон түүх”, “Хүйтэн уулын бичиг”, “Улаан асрын зүүд” гэх дөрвөн алдартай номыг орчуулсан. Эдгээр алдартай бүтээлийг эрдэмтэн Балданцэрэн, Ядамсүрэн, Цэндсүрэн, Даваа, Өлгийт, Шагдаржав, Сэнгэбадрах гэх мэт хүмүүс орчуулжээ.

Энэ мэт Хятадын алдартай олон бүтээлийг монголын эрдэмтэд монгол хэл рүү орчуулсан. Нийт 700 бүтээл өдгөөг хүртэл манай улсын Улсын номын санд хадгалагдсаар байна.

4. Гүн ухааны судалгаа:

Гүн ухааны судалгаатай холбогдолтой “4 ном 5 судар”-ыг монгол хэл рүү орчуулсан төдийгүй төвд хэлнээс монгол хэл рүү орчуулсан гүн ухааны бүтээлийг тоочиж барахгүй. Энэ нь монголчууд тухайн үед хятад судлалыг улам гүнзгий судалж байсныг баталж байгаа юм.

Ардын хувьсгалын дараа (1921 он) манай улсад хятад судлалыг шаргуу хийж, эн тэргүүний чухал ажил болгосон. Ардын хувьсгал ялсаны дараа манай улсын эрдэмтэд төвд, манж хэлээр дамжуулан хятадыг судлахаас гадна орос хэлээр дамжуулан хятад судлалыг гүнзгийрүүлэн хийж байлаа.

Нэгтгэн хэлбэл, ардын хувьсгалын дараа манай улсын сэхээтнүүд хятад судлалын тал дээр дээд сургуульд гадаад улсын түүх, бичгийн соёл болон шинжлэх ухааны судалгаа, бичигдсэн зохиол бүтээл гэх мэт тал дээр Орос, Зөвлөлтийн эрдэмтэн Палладий Кафаров, Н.Я.Бичурин, В.М.Алексеев, В.Н.Васильев, И.М.Овсяняев, В.С.Каракиров,

Н.Федеренко, Г.В.Ефимов, Никифоров, Л.В.Семеновская, Г.Б.Оренбург гэх мэт Орос, Зөвлөлтийн эрдэмтдийн бичсэн хятад-орос толь болон бусад холбогдох зохиол бүтээл нь манай улсын хятад судлаачид болон Их сургуулийн хятадын түүхийн багш нарын тайлбарлан заах нэн тэргүүний гарын авлага болсон. Зөвлөлтийн хятад судлаачид манай улсын хятад судлалын боловсон хүчинг бэлтгэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэж, зөвлөлтийн хятад судлаачдын бэлтгэн гаргасан олон хүн одоо манай шинжлэх ухаан судалгааны байгууллагуудад ажиллаж байна.

1949 онд БНХАУ байгуулагдаж манай хоёр улс, улс төр, эдийн засаг соёлын харилцаа тогтоосноос хойш манай улсын хятад судлал цоо шинэ шатандаа оржээ.

БНХАУ-ын хятад судлалын мэргэжилтэнгүүд манай улсын хятад судлалын судалгааны ажилтанг бэлтгэхэд туйлын их анхаарч байна. Энд Бээжингийн Их сургуулийн профессор Жянь Бозан, Шао Сюньжэн, Жоу И лян, Ванли, Гао Минкай болон Хятадын шинжлэх ухааны академийн түүх судлаач профессор Вэн Дужянь, Өвөр Монголын түүх, хэл бичгийн хүрээлэнгийн захирал Эрдэнэтогтох гэх мэт хүмүүсийг дурьдах хэрэгтэй. Хятадын мэргэжилтэнгүүдийн сурган хүмүүжүүлсэн монголын оюутнууд хятадад сургууль төгсөөд улсдаа буцаж ирэн хятад судлалын судалгааны ажил хийж байна. Одоо манай хятад судлалын нөхцөл улам сайжирч манай хятад судлаачид хятад хэл дээрхи холбогдох судалгааны материалыг шууд уншиж танилцуулж байна. Бид толь болон орчуулгын ном судрын ажлаар урьд нь хязгаарлагддаг байсан бол одоо манай хятад судлаачид онцгойлон улам олон хятад судлалын ном, бүтээл холбогдох судалгааны өгүүлэл бичихэд ихээхэн анхаарч байна.

Ойрын хэдэн жилд, манай улсад хятадын түүхийн холбогдолтой “1917-1924 оны Хятад улс”, “1924-1927 оны Хятад улс”, “1927-1937 оны Хятад улс”, “1937-1990 оны Хятад улс” гэсэн 4 номыг хэвлүүлсэн бөгөөд зохиогч Ш.Бира эдгээр номоо 1954-1957 онд тус тус хэвлэн гаргажээ.

1956 онд Б.Жамбалдоржийн “Хятадын ард түмэн”, Ч.Далайн бичсэн “БНХАУ”, С.Норовсамбуугийн “Марксизм-ленинизмийг бүтээлчээр хэрэглэж Хятадын хувьсгалыг удирдсан Мао Зэдун” номнууд хэвлэгдэж уншигчдын гар дээр очсон юм.

Одоо манай улсын эрдэмтэд “БНХАУ-ын товч түүх” ном бичиж байгаа ба Хятадын шинжлэх ухаан, соёл, аж үйлдвэрийн талаар зохиол бүтээлийг уншигчдад танилцуулж байна.

Хэлний тал дээр: Улсын их сургуулийн хятад хэлний тэнхимийн залуу багш Ө.Гүрсэд болон Улсын их сургуулийн хятад хэлний тэнхимд багшаар ажиллаж буй хятад хэлний мэргэжилтэн нөхөр Лю Линтэй хамт хятад хэлний факультетийн оюутнуудын хэрэглэх сурах бичиг хэвлүүлжээ. (энэ номын монгол хэлээр тайлбарласан эх одоо хэвлэлтэнд байгаа)

Төвд хэлний профессор Дорж гурван боть төвд хэлний сурах бичиг бичиж хэвлүүлсэн. Нөхөр Гүрсэд “Монгол-Хятад ярианы дэвтэр” номоо

хоёр удаа хэвлүүлэн гаргасан нь хятад хэл сурах монгол уншигчдад маш чухал хэрэгцээтэй ном болсон юм.

Нөхөр Чой.Лувсанжавын удирдлагаар “Хятад-Монгол хэлц үгийн толь бичиг”-ийг гар бичмэлээр нь хувиран гаргаад байна. Бид одоо Монгол-Хятад толь бичиг зохиох ажлыг эхлүүлэхээр бэлтгэж байгаа ба Манж хэлний сурах бичиг зохиох ажлыг бас эхлээд байна.

Утга зохиолын тал дээр: Улсын их сургуулийн Хятад хэлний факультетэд хятадын уран зохиолын хичээлийг монгол багш зааж байна.

Хятад хэлний факультетийн оюутан бас хятадын уран зохиолын номыг орчуулах ажлыг хийж байна.

Манай улс хятадын уран зохиолын алдартай бүтээл Лу Шүний “Галзуу хүний өдрийн тэмдэглэл”, “А Кыогийн үнэн түүх”, Го Можогийн шүлгийн түүвэр “Шанхайн өглөө”, алдарт жүжиг “Чу Юань”, Жоу Либогийн “Догшин салхи ширүүн бороо”, Мао Дунгийн “Үнэгэн харанхуйд”, Ба Жингийн “Гэр бүл”, У Юндугийн “Аливаа бүхнээ намдаа”, Чу Богийн “Хөвч ой цасан тал” зэрэг зохиолуудыг орчуулан хэвлүүлсэн. Манай улсын уран зохиолын хэвлэл дээр хятад улсын шилдэг богино өгүүлэл байнга хэвлэгдэж байгааг монголын уншигчид таатайгаар хүлээн авсан. Жишээ нь: Ван Юаньжян “Намын зарлага”, “Ээж” гэх мэт.

Агуу их хятадын ард түмний эртний түүх, орчин үеийн түүх, шинэ үеийн түүх болон эрт эдүгээгийн утга зохиолын судалгааг гүнзгийрүүлэхийн тулд 1957 оноос эхлэн манай улсын их сургуульд албан ёсоор хятад хэл, төвд хэл, манж хэлний анги үүсгэн байгуулж, одоо 100 гаруй оюутан энэ гурван ангид сурч байна.

Хятад хэл бичгийн ангид бэлтгэн гаргасан оюутнуудын нэг хэсэг нь орчуулгын ажил хийж байгаа бол ихэнх хэсэг нь хятад хэл, түүхийн эрдэм шинжилгээний ажил эрхэлж байна.

Хэдийгээр төвд, манж хэлний ангийн оюутан цөөн байгаа ч тэд бүгд эрдэм шинжилгээний ажил хийх юм.

Энэ оны сүүлийн хагас жилд манайд хятад судлалын дугуйлан байгуулагдлаа. Дугуйлангийн гишүүд нь хятадын түүх, улс төр, уран зохиол, хэлийг судалж мөн толь бичих, зохиох болон хятадын түүхийн талаар судалгаа хийж байна. Бид төлөвлөсөний дагуу иймэрхүү замаар хятад судлаачдыг бэлтгэн гаргаж байна.

Манай эрдэмтэд Хятад улсын түүхийг судлахын зэрэгцээ Монголын эртнээс нягт гүн зузаан түүхэн харилцаатай агуу их хоёр хөрш орон Зөвлөлт Холбоот Улс, БНХАУ болон бусад улсуудтай төрөл бүрийн судалгааны ажлыг явуулж байгаа ба энэ талын судалгаа нь одоо маш чухал болоод байна.

Хоёр том хөрш улсынхаа түүхийг мэдэх нь манай улсын түүхийн судалгаанд чухал ач холбогдолтой. Хятад судлалын талаар бид тодорхой төлөвлөгөө гаргасан бөгөөд хэдэн жилийн дараа үүндээ хүрнэ гэдэгт итгэж байгаа.

Бид хүндэт хятад судлаач бүрийг хятад судлалын судалгаандаа ихээхэн хичээл чармайлт гарган амжилт олохыг хүсэж байна.

Эцэст нь миний бие БНМАУ-ын хятад судлаачдыг төлөөлөн энэ удаагийн хурал амжилттай болохыг хүсэн ерөөе.

Эрхэм хятад судлаачид цаашид шинжлэх ухааны судалгааны ажилдаа гялалзсан амжилт гарган ажиллахыг хүсэн ерөөе.

*Хятад хэлнээс орчуулсан Д.Батжаргал (ОУСХ-ийн эрдэм
шинжилгээний ажилтан, магистр)*